

ТАЙВАНИЙН ХЯНАЛТЫН ЮАНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ, ЛАВЛАГАА

Г.Билгээ, О.Нарантуяа, П.Уранчимэ

АГУУЛГА

Хяналтын Юаны эрх зүйн орчин

Хяналтын Юаны бүрэлдэхүүн

Хяналтын Юаны бүтэц, зохин байгуулалт

Хяналтын Юаны нэгдсэн хуралдаан

Хяналтын Юаны хороод

Хяналтын Юаны эрх, үүрэг

1) Иргэдийн өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэх

2) Мөрдөн шалгах

3) Зөрчил арилгах арга хэмжээ

4) Итгэл үзүүлэх эсэх

5) Хариуцлага тооцох

6) Албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээх авах

Аудитын үйл ажиллагаа

Хүний эрхийн үндэсний комиссын үйл ажиллагаа

ХАВСРАЛТУУД


Хавсралт 1. Тайванийн Үндсэн хуулийн Хяналтын Юантай холбоотой зохицуулалт

Хавсралт 2. Тайванийн Хяналтын Юаны тухай хууль

Хавсралт 3. Тайванийн Хяналтын тухай хууль

Хавсралт 4. Хяналтын Юаны бүтэц, зохион байгуулалтын схем

Хавсралт 5. Хяналтын Юаны хяналтын үйл ажиллагааны зураглал



СУДАЛГААНЫ ХЭСЭГ

1947 онд батлагдсан Тайванийн Үндсэн хуулиар¹⁷⁷ (Хавсралт 1.) тус улсад Гүйцэтгэх, Хууль тогтоох, Шүүх, Шалгалт (Examination) болон Хяналт (Control) гэсэн таван Юан бүхий Төв засгийн газрыг байгуулжээ.¹⁷⁸ (Зураг 1.)

Төв засгийн газрыг Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч нар удирдана.

Зураг 1. Төв Засгийн газрын бүтэц

Хятадын төрийн зүтгэлтэн, эмч, улс төрийн гүн ухаантан Сун Ят Сен¹⁷⁹ нь барууны уламжлалт эрх мэдлийн хуваарилалтын гурван салбар



дээр Хятадын эзэнт гүрний үеийн Шалгалтын Юан (Examination Yuan), Хяналтын Юан (Control Yuan) гэсэн хоёр салбарыг нэгтгэсэн эрх мэдлийн хосолсон загвар (hybrid model)-ыг хөгжүүлэхийг дэмжиж байжээ.¹⁸⁰

Хяналтын Юаны эрх зүйн орчин

Тайванийн Хяналтын Юаны эрх зүйн үндсийг Үндсэн хуулиар тогтоосон бөгөөд дараах хууль, журмаар нарийвчилсан харилцааг зохицуулна.¹⁸¹ Үүнд:

- Хяналтын хууль (Control Act);
- Хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах журам (Enforcement Rules of the Control Act);
- Төрийн албан хаагчдын өмч хөрөнгө мэдүүлэх тухай хууль (Act on Property-Declaration by Public Servants);
- Төрийн албан хаагчдын өмч хөрөнгө мэдүүлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах журам (Enforcement Rules of the Act on Property-Declaration by Public Servants);

¹⁷⁷ Constitution of the Republic of China (Taiwan). Announced Date: 1947-01-01. <https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=A0000001>

¹⁷⁸ Government Portal of the Republic of China (Taiwan) - <https://www.taiwan.gov.tw>

¹⁷⁹ Сун Ят Сен (Sun Yat-sen) (1866-1925) - БНХАУ-ын анхны түр ерөнхийлөгч (1912 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 03 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл), Гоминдан (Хятадын үндэсний нам)-ы анхны удирдагч байсан.

¹⁸⁰ Chinese Constitutionalism: Five-Power Constitution. Ernest Caldwell. Max Planck Encyclopedia of Comparative Constitutional Law (Forthcoming 2017).

¹⁸¹ <https://www.cy.gov.tw/en/News.aspx?n=256&sms=8939>

- Ашиг сонирхлын зөрчлийн улмаас төрийн албанаас хасах тухай хууль (Act on Recusal of Public Servants Due to Conflict of Interest);
- Ашиг сонирхлын зөрчлийн улмаас төрийн албанаас хасах тухай хуулийн хэрэгжилтийг хангах журам (Enforcement Rules of the Act on Recusal of Public Servants Due to Conflicts of Interest);
- Улс төрийн хандивын тухай хууль (Political Donations Act);
- Аудитын тухай хууль (Audit Act);
- Хяналтын Юаны тухай органик хууль (Organic Law of the Control Yuan);
- Хяналтын Юаны Хороодын тухай органик хууль (Organic Act of the Control Yuan Committees);
- Хяналтын Юаны Хүний эрхийн үндэсний комиссын тухай органик хууль (Organic Act of the Control Yuan National Human Rights Commission);
- Хяналтын Юанд иргэдээс бичгээр ирүүлсэн гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх журам (Regulations for Receiving and Handling People’s Written Complaints Submitted by the Control Yuan);
- Хяналтын Юаны схемчилсэн хяналтыг зохицуулах журам (Regulations Governing Circuit Supervision by the Control Yuan).

Хяналтын Юаны бүрэлдэхүүн

Хяналтын Юаны тухай органик хуулийн 3-1 дүгээр зүйлд зааснаар Хяналтын Юаны гишүүд нь 35 нас хүрсэн байх ба дараах шалгууруудын аль нэгийг хангасан байна. Үүнд:

1. хууль тогтоох байгууллагын гишүүнээр 1-ээс доошгүй удаа, эсхүл хотын тусгай зөвлөлийн гишүүнээр 2-оос доошгүй удаа нэр хүндтэй ажилласан байх;
2. 12-оос доошгүй түвшний шүүгч, прокуророор 10-аас доошгүй жил, эсхүл Дээд шүүх, Захиргааны хэргийн дээд шүүх, Дээд шүүхийн Прокурорын газар болон түүнээс дээш шатны шүүхийн шүүгч, прокуророор нэр хүндтэй ажилласан байх;
3. сонгосон зэрэглэл (Selected Rank)-д төрийн албан хаагчаар 10-аас доошгүй жил нэр хүндтэй ажилласан байх;
4. их сургуулийн профессороор 10-аас доошгүй жил нэр хүндтэй ажилласан байх;
5. дотоодын Мэргэжлийн болон Техникийн ахисан түвшний шалгалт (Professional and Technical Senior Examination)-д тэнцсэн, мэргэжлээрээ 15-аас доошгүй жил нэр хүндтэй ажилласан байх;
6. улс төрийн арвин туршлагатай, эсхүл сэтгүүл зүй, соёлын үйл ажиллагааг удирдаж байсан туршлагатай, нэр хүндтэй, шударга, ухамсартай хүн;

7. нэр хүндтэй, хүний эрхийг хамгаалах чиглэлийн судлаач, эсхүл хүний эрхийг хамгаалагч, эсхүл иргэний нийгмийн байгууллагад хүний эрхийг хамгаалах, дэмжих чиглэлээр ажиллаж байсан туршлагатай хүн.

Дээрх жагсаалтын 7-д заасан шаардлага хангасан гишүүний тоо долоо байх ба сул орон тоо байх ёсгүй.

Хяналтын Юаны гишүүдийн бүрэлдэхүүн нь үндэстэн ястан, мэргэжлийн салбарын төлөөлөгчдийг багтаасан байна. Бүрэлдэхүүний хүйсийн тэгш байдлыг хангах үүднээс аль нэг хүйс нь 1/3-ээс доошгүй хувийг бүрдүүлнэ. Гишүүдийг нэр дэвшүүлэхээс өмнө иргэний нийгмийн байгууллагуудын саналыг нээлттэй авч үзнэ.

Үндсэн хуулийн 92 дугаар зүйлд зааснаар Хяналтын Юан нь гишүүдээсээ сонгосон Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгчтэй байна. Хяналтын Юаны тухай органик хуулийн 6 дугаар зүйлд зааснаар Хяналтын Юаны Ерөнхийлөгч нь тус Юаны үйл ажиллагаанд болон харьяа агентлагуудад хяналт тавина.

Тойргийн хяналт ба мөрдөн шалгалт

Хяналтын тухай хуулийн 3 дугаар зүйлд Хяналтын Юаны гишүүд төв болон орон нутгийн хэмжээнд тойргийн хяналтыг явуулна гэж заасан. Төвийн түвшинд тойргийн хяналтыг үйл ажиллагаатай нь хамаарал бүхий байнгын хороод, орон нутагт нь засаг захиргааны бүсээр нь ялгаж, багаар гүйцэтгэдэг.

Хяналт нь дараах салбаруудыг хамаарна.

1. Ерөнхий захиргаа, төсвийн гүйцэтгэл;
2. Төрийн бодлого, зохицуулалтын хэрэгжилт;
3. Төрийн албан тушаалтан албан үүрэгтээ хайнга хандах;
4. Хяналтын Юанаас үүрэг болгосон сайжруулах талаарх арга хэмжээний хэрэгжилт;
5. Ард түмний амьжиргаа, нийгмийн байдал;
6. Иргэдийн өргөдөл, гомдол, түүнтэй холбоотой бусад асуудлыг шийдвэрлэх.

Хяналтын Юаны бүтэц, зохион байгуулалт

Хяналтын Юаны тухай органик хууль (Organic Law of the Control Yuan¹⁸²)-д заасны дагуу Хяналтын Юан нь хороод, Хүний эрхийн үндэсний комисс,

¹⁸² Organic Law of the Control Yuan. Promulgated on March 31, 1947. <https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=A0010071>

Үндэсний аудитын газар, дүүргүүд дэх хяналтын захиргааны албууд (district administrative offices)-ыг байгуулна.

Мөн Хяналтын Юан нь дараах нэгжийг байгуулна:

- Хяналтын үйл ажиллагааны газар (Department of Supervisory Operations);
- Мөрдөн шалгах газар (Department of Supervisory Investigation);
- Төрийн албан хаагчдын өмч хөрөнгийн мэдүүлгийн газар (Department of Property-Declaration by Public Servants);
- Тамгын газар (Secretariat);
- Зохицуулалт, төлөвлөлтийн газар (Department of Coordination and Planning).

Эдгээр нэгжүүд нь дараах асуудлуудыг шийдвэрлэнэ. Үүнд:

1. иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах, боловсруулах, санал гаргахтай холбоотой асуудал;
2. хариуцлага тооцох асуудал;
3. мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой хамтран шалгах асуудал;
4. төрийн албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчлийн улмаас төрийн албанаас хассан, улс төрийн хандив, лоббитой холбоотой асуудал;
5. хуралдааны тэмдэглэл хийх, олон нийтэд зориулсан тайланг эмхэтгэх, хэвлэх;
6. баримт бичиг хүлээн авах, олгох, тамга тэмдэг хадгалах, хэрэглэх;
7. төрийн сангийн болон ерөнхий үйл ажиллагаа;
8. цогц төлөвлөгөө боловсруулах, судалгаа, боловсруулалт, үнэлгээ хийх;
9. мэдээллийн төлөвлөгөө, систем, тоног төхөөрөмж, аюулгүй байдал, сургалтын ерөнхий төлөвлөлтийн менежменттэй холбоотой асуудал;
10. зохицуулалт, уялдаа холбоо, мэдээ мэдээлэлтэй холбоотой асуудал;
11. холбогдох бусад асуудал.

Мөн Хяналтын Юаны тухай органик хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу Хяналтын Юан нь Нягтлан бодох бүртгэлийн алба, Статистикийн алба, Боловсон хүчний алба, Ёс зүйн албыг байгуулна. (Хавсралт 3.)

Хяналтын Юаны нэгдсэн хуралдаан

Хяналтын Юаны нэгдсэн хуралдаан нь Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, гишүүдээс бүрдэх бөгөөд Ерөнхийлөгч сар бүр хуралдуулдаг. Нэгдсэн хуралдааныг Ерөнхийлөгч даргалах ба түүний эзгүйд Дэд Ерөнхийлөгч энэ үүргийг гүйцэтгэнэ. Хэрэв хоёулаа байхгүй бол хуралдаан даргалагчийг гишүүдээс сонгоно. Хяналтын Юаны нэгдсэн хуралдааны кворум нь гишүүдийн тал хувь байдаг.¹⁸³

Хяналтын Юаны нэгдсэн хуралдаанд дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:

- Хууль тогтоох Юанд өргөн мэдүүлэх хуулийн төсөл;
- Хяналтын Юаны эрх зүйн байдалтай холбоотой асуудал;
- төрийн захиргааны төв болон орон нутгийн төсөвт хийсэн аудитын тайлантай холбоотой асуудал;
- итгэл үзүүлэх эсэх (impeachment), хариуцлага тооцох болон аудит хийх бүрэн эрхийг сайжруулахтай холбоотой асуудал;
- зөрчил арилгах арга хэмжээг сайжруулахтай холбоотой асуудал;
- байнгын болон онцгой хороотой холбоотой асуудал;
- Хүний эрхийн үндэсний комисстой холбоотой асуудал;
- Юаны Ерөнхийлөгчийн тавьсан асуудал;
- Юаны гишүүдийн тавьсан асуудал болон бусад чухал асуудлууд.

Хяналтын Юаны хороод

Үндсэн хуулийн 96 дугаар зүйл, Хяналтын Юаны хороодын органик хууль (Organic Act of the Control Yuan Committees)-ийн 2 дугаар зүйлд заасны дагуу Хяналтын Юан дараах 7 хороог байгуулсан.¹⁸⁴ Үүнд:

- Дотоод болон угсаатны асуудал эрхэлсэн хороо;
- Гадаад хэргийн болон үндэсний батлан хамгаалахын асуудал эрхэлсэн хороо;
- Нийгмийн хамгаалал, байгаль орчны эрүүл ахуйн асуудал эрхэлсэн хороо;
- Санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн хороо;
- Боловсрол, соёлын асуудал эрхэлсэн хороо;
- Тээвэр, худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн хороо;
- Шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн асуудал эрхэлсэн хороо.

Хороод нь Хяналтын Юаны гишүүдээс бүрдэнэ. Гишүүн бүр гурваас илүүгүй хорооны бүрэлдэхүүнд орох ба бусад хороодод саналын эрхгүй гишүүнээр оролцож болно. Хороо нь 14 хүртэл гишүүнтэй байх бөгөөд дундаасаа хорооны даргыг сонгоно.

¹⁸³ <https://www.cy.gov.tw/en/cp.aspx?n=233>

¹⁸⁴ <https://www.cy.gov.tw/en/cp.aspx?n=235>

Хяналтын Юаны хороодын органик хуулийн 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт заасны дагуу Хяналтын Юан дараах 4 тусгай хороог байгуулав. Үүнд:


- Хууль зүйн судалгааны хороо;
- Зөвлөлдөх хороо;
- Юаны гишүүдийг хянах сахилгын хороо;
- Авлигатай тэмцэх хороо.

Хяналтын Юаны эрх, үүрэг

Хяналтын Юаны эрх, үүрэг¹⁸⁵

- 1) Иргэдийн өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэх (Receipt of People's Complaints);
- 2) Мөрдөн шалгах (Investigation);
- 3) Зөрчил арилгах арга хэмжээ (Corrective Measures);
- 4) Итгэл үзүүлэх эсэх (Impeachment);
- 5) Хариуцлага тооцох (Censure);
- 6) Албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээх авах.

Control Yuan Powers



¹⁸⁵ <https://www.cy.gov.tw/en/cl.aspx?n=237>

1) Иргэдийн өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэх

Хяналтын тухай хуулийн 4 дүгээр зүйлд Хяналтын Юан болон түүний гишүүд иргэдээс бичгээр гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авна гэж заасан. Хяналтын тухай хуульд заасан иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх журмын дагуу гомдол гаргагч нь төрийн албан хаагчийн хууль бус үйлдэл, зөрчилд гэм буруутайг нотлох баримт болон түүний жагсаалтыг Хяналтын Юан, эсхүл түүний гишүүдэд шууд мэдээлнэ.

Хяналтын Юан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах ажилтныг өдөр бүр ажиллуулна. Ажилтан нь бичгээр гаргасан өргөдөл, гомдолд дурдсан баримтыг үндэслэн холбогдох гишүүн болон байгууллагад шалгуулахаар шилжүүлэх, эсхүл зохих журмын дагуу шийдвэрлэнэ. Харин уг хэрэг нь Хяналтын Юанд хамаарахгүй бол гомдлыг хүлээн авахгүй. Өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэсний дараа Хяналтын үйл ажиллагааны газар гомдол гаргагчид бичгээр хариу мэдэгдэнэ.

2) Мөрдөн шалгах

Хяналтын Юан нь хяналтын эрхээ хэрэгжүүлэхдээ БНХАУ-ын Үндсэн хуулийн 95 дугаар зүйлд заасны дагуу Гүйцэтгэх Юан, яам, зөвлөл, комиссоос гаргасан бүх тушаал шийдвэр, холбогдох баримт бичгийг хянах бүрэн эрхтэй. Хяналтын тухай хуулийн 26 дугаар зүйлд хяналтын тусгай зөвшөөрөлтэй Хяналтын Юаны гишүүн, эсхүл Хяналтын Юанаас томилогдсон ажилтан болон мөрдөн байцаалтын тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий ажилтан төрийн болон хувийн хэвшлийн байгууллага дээр очиж хавтаст хэрэг, холбогдох баримт бичигтэй танилцаж болно гэж заасан. Дээрх байгууллагын дарга, холбогдох бусад албан хаагчид шалгалт явуулахад татгалзах эрхгүй. Хяналтын Юан нь төрийн албан хаагчид болон захиргааны байгууллагын хууль бус үйлдэл, зөрчилд хариуцлага хүлээлгэх, буруутгах, засч сайжруулах талаар арга хэмжээ авах санал хүргүүлэх бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Төрийн албан хаагчийн хууль бус үйлдэл, эсхүл захиргааны байгууллагын хууль бус үйлдлийг тогтоохын тулд заавал нотлох баримт шаардлагатай. Тиймээс үнэнийг илрүүлэх нь мөрдөн шалгалтын явцад буруутгах, яллах, засч сайжруулах арга хэмжээг санал болгох эрх мэдлийн үндэс болдог.

Хяналтын Юаны мөрдөн шалгалтыг гурван төрөлд хувааж болно:

- үүрэг болгосон мөрдөн шалгалт;
- томилсон мөрдөн шалгалт;
- өөрөө эхлүүлсэн мөрдөн шалгалт.

Үүрэг болгосон мөрдөн шалгалт нь иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шалгахыг холбогдох байгууллагуудад даатгадаг. Томилсон мөрдөн шалгалт нь Хяналтын Юан, эсхүл Хорооны тогтоолоор мөрдөн шалгах ажиллагаа явуулахаар гишүүдийг ээлжлэн (rotation) томилдог. Гишүүд иргэдийн өргөдөл, гомдол болон бусад мэдээллийн үндсэн дээр холбогдох байгууллагад бүртгүүлж, өөрийн санаачлагаар мөрдөн байцаалтын ажиллагаа эхлүүлэхийг өөрөө эхлүүлсэн мөрдөн шалгалт гэж нэрлэдэг. Хяналтын Юан нь томилсон болон өөрөө эхлүүлсэн мөрдөн шалгалтын ажиллагаанд туслах мөрдөн байцаагч томилно.



3) Зөрчил арилгах арга хэмжээ (Corrective Measures)

Хяналтын тухай хуулийн 24 дүгээр зүйлд Хяналтын Юан, Гүйцэтгэх Юан болон түүний харьяа байгууллагуудын ажил, үйлчилгээг шалгасны дараа холбогдох хорооны хурлаар хэлэлцэн баталж, засч сайжруулах арга хэмжээг Гүйцэтгэх Юан, эсхүл түүний харьяа байгууллагуудад арга хэмжээний саналыг хүргүүлнэ гэж заажээ. Гүйцэтгэх Юан болон түүний харьяа байгууллагууд саналыг хүлээн авсны дараа нэн даруй арга хэмжээ авч, Хяналтын Юанд бичгээр хариу өгнө.

Хэрэв арга хэмжээг хэрэгжүүлээгүй, эсхүл Хяналтын Юанд хоёр сарын дотор хариу ирүүлээгүй бол Хяналтын Юан холбогдох хорооны хурлаас гаргасан тогтоолоор тухайн байгууллагад бичгээр асуулга тавих, эсхүл эрх бүхий албан тушаалтныг дуудан байцаах үүрэгтэй.

4) Итгэл үзүүлэх эсэх

Хяналтын Юан нь төрийн төв болон орон нутгийн захиргааны албан хаагч албан үүрэгтээ хайхрамжгүй хандсан, хууль зөрчсөн гэж үзвэл хариуцлага тооцох хэрэг үүсгэнэ.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Хяналтын тухай хуульд зааснаар төрийн өндөр албан тушаалтанд итгэл үзүүлэх эсэх асуудлыг Хяналтын Юаны хоёроос доошгүй гишүүн санаачлах бөгөөд санаачлагчаас бусад 9-өөс доошгүй гишүүн шалган тогтооно. Шалгалтын дараа хэргийг Сахилгын шүүхэд шилжүүлнэ.

Хяналтын Юаны бүх гишүүд ээлжлэн итгэл үзүүлэх эсэх асуудлыг шалгах шалгалтын хороонд орно. Уг хэрэгт холбогдолгүй 13 гишүүн оролцоно. Хэрэв итгэл үзүүлэх эсэх асуудал нь шалгалтад тэнцээгүй, мөн хэрэг үүсгэсэн гишүүд огцруулах үндэслэлтэй байна гэж үзвэл тус хэргийг өөр 9 гишүүнээс бүрдсэн шалгалтын комисс дахин хянан үзэх бөгөөд тус шалгалтын комиссын шийдвэр эцсийнх байна.

Хэрэв албан хаагч албан үүрэгтээ хайхрамжгүй хандсан, хууль зөрчсөн үйлдэл нь нэн даруй арга хэмжээ авахуйц ноцтой бол тухайн этгээдийн дээд шатны байгууллагад хэргийг шилжүүлнэ. Хэрэв эрүүгийн хууль зөрчсөн бол холбогдох шүүхэд шилжүүлнэ.

Хяналтын Юаны Ерөнхийлөгч итгэл үзүүлэх эсэхийг шийдвэрлэх ажиллагааг удирдах бөгөөд хөндлөнгөөс оролцохгүй. Шалгалтын арга хэмжээ дуусахаас өмнө итгэл үзүүлэх эсэхтэй холбоотой хэргийг нууцлах бөгөөд шалгалтаар тогтоогдсоны дараа Хяналтын Юаны мэдэгдлийг олон нийтэд мэдээлнэ.

Сахилгын шүүх яллагдагчаас мэдүүлэг авсан бол мэдүүлгийг нэн даруй Хяналтын Юаньд хүргүүлэх бөгөөд түүнийг итгэл үзүүлэх эсэх асуудлаар хэрэг үүсгэсэн гишүүдэд нэн даруй илгээнэ. Санаачлагч гишүүд мэдүүлэг хүлээн авснаас хойш арав хоногийн дотор Сахилгын шүүхэд саналаа хүргүүлнэ.

5) Хариуцлага тооцох

Хяналтын Юаны гишүүн төрийн албан хаагч албан үүрэгтээ хайхрамжгүй хандсан, хууль зөрчсөн болохыг тогтоосон бол түүнийг албан тушаалаас түдгэлзүүлэх, эсхүл нэн даруй арга хэмжээ авах шаардлагатай гэж үзвэл төрийн албан хаагчийн эсрэг бичгээр хариуцлага тооцох талаар бичиж болно. Хяналтын Юан нь уг хүсэлтийг гурав ба түүнээс дээш гишүүний бүрэлдэхүүнтэй хянан хэлэлцэх бөгөөд шийдвэрээ тухайн төрийн

албан хаагчийг хариуцсан албан тушаалтанд хүргүүлнэ. Энэ асуудал нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжтэй бол эрүүгийн хэрэг үүсгэн шалгуулахаар эрх бүхий шүүхэд шилжүүлнэ.

Бичгээр сануулга хүлээн авсан албан хаагч, түүний дарга нь нэг сарын дотор Төрийн албан хаагчийн сахилгын тухай хуульд заасан журмын дагуу зохих арга хэмжээ авна. (Эрүүгийн хууль, Зэвсэгт хүчний эрүүгийн хуультай холбоотой асуудлыг холбогдох хяналтын байгууллагууд нь шийдвэрлэдэг).

Удирдах албан тушаалтан нь сануулга авсан этгээдийг үүрэгт ажлаас нь түдгэлзүүлэх, эсхүл бусад арга хэмжээ авч болно. Хэрэв дээд албан тушаалтан нь ямар нэгэн арга хэмжээ авах шаардлагагүй гэж үзвэл тайлбараа Хяналтын Юанд хүргүүлнэ. Хэрэв удирдах албан тушаалтан нь хуулийн дагуу арга хэмжээ аваагүй, эсхүл Хяналтын Юаны хоёроос дээш гишүүн энэ үйлдлийг зохисгүй гэж үзвэл буруутгагдаж буй этгээдэд итгэл үзүүлэх эсэх асуудлаар санал гаргаж болно. Хэрэв итгэл үзүүлэх эсэх асуудал нь буруутгагдсан этгээдэд торгууль ногдуулахад хүрвэл, үүрэг хариуцлага алдсаны хариуцлагыг түүний дарга хүлээнэ.

6) Албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээх авах

Төрийн албан хаагчдын өмч хөрөнгө мэдүүлэх тухай хуулийн 2 дугаар зүйлд дараах албан тушаалтнууд хөрөнгө орлогын мэдүүлгээ Хяналтын Юанд тайлагнана.

- БНХАУ-ын Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч;
- таван Юанын Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч нар;
- улс төрийн томилогдсон албан тушаалтнууд;
- Ерөнхийлөгчийн Тамгын газрын орон тооны ахлах зөвлөх, үндэсний бодлогын зөвлөх, стратегийн зөвлөхүүд;
- Төрийн байгууллагын удирдах албан тушаалтан (12 дугаар түвшин буюу түүнээс дээш түвшин эсхүл түүнтэй адилтгах), төрийн өмчит аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтнууд, үндсэн болон салбар, харьяа төрийн байгууллагын дарга, дэд дарга, төрийн болон олон нийтэд томилогдсон шүүхийг төлөөлж буй дарга, зөвлөх нар;
- улсын коллежоос дээш боловсролын байгууллагын захирал, тэдгээрийн харьяа байгууллагын дарга нар;
- хошууч генералаас дээш зэрэглэлийн цэргийн ангиудын дарга нар;
- Төрийн албан хаагчдыг сонгох, эгүүлэн татах тухай хуулийн дагуу сонгогдсон суурин (хот)-аас дээш газрын төрийн байгууллагын дарга нар;

- бүх түвшний ард түмний төлөөлөл;
- дээд шатны (6-аас дээш түвшний) шүүгч, прокурор.

Мөн хуулийн 12 дугаар зүйлд зааснаар хөрөнгө орлогын мэдүүлгээ үнэн зөв тайлагнах ёстой албан тушаалтан санаатайгаар нуун дарагдуулсан бол 200.000-аас дөрвөн сая ам.доллар хүртэл торгууль ногдуулна. Хэрэв хөрөнгө орлогын мэдүүлгийн жилийн тайланг харьцуулан үзэхэд төрийн албан хаагч, түүний эхнэр, нөхөр, тэдний асрамжид байдаг хүүхдийн нийт орлого хоёр дахин нэмэгдсэн нь тогтоогдвол тухайн төрийн албан хаагчид нэг сарын хугацаанд хөрөнгө орлогын мэдүүлгийн талаарх тайлбар гаргахыг зөвшөөрнө.

Дараах хууль тогтоомжоор зохицуулна:

- Ашиг сонирхлын зөрчлийн улмаас төрийн албанаас хасах тухай хууль (Act on Recusal of Public Functionaries Due to Conflicts of Interest);
- Өргөдлийн бүртгэлийг зохицуулах, өөрчлөх, эсхүл лобби хийх хэргүүдийг дуусгавар болгох тухай (Handling Registration for the Application, Change, or Termination of Lobbying Cases);
- Улс төрийн хандивын дансыг батлах, өөрчлөх, хаах, дансны бүртгэлийн мэдүүлгийг зохицуулах тухай (Handling the Approval, Change, and Closing Political Donation Accounts, and the Declaration of Account Records).

Аудитын үйл ажиллагаа

Үндсэн хуулийн 90 дүгээр зүйл, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн 7 дугаар зүйлд зааснаар аудитын эрх мэдэл нь хяналтын эрх мэдлийн нэг юм.

Хяналтын Юаны тухай органик хуулийн 5 дугаар зүйлд зааснаар Ерөнхий аудитор нь Үндэсний аудитын газрын үйл ажиллагаанд хяналт тавина.

Үндсэн хуулийн 105 дугаар зүйлд Ерөнхий аудитор нь Төв засгийн газрын жилийн тайланг Гүйцэтгэх Юанд ирүүлснээс хойш 3 сарын дотор тайланд аудит хийж, аудитын тайлангаа Хууль тогтоох Юанд өргөн мэдүүлнэ.

Аудитын тухай хуулийн 2 дугаар зүйлд зааснаар аудитын эрх мэдэлд дараах асуудлууд хамаарна. Үүнд:

- төсвийн хэрэгжилтэд хяналт тавих;
- төлбөрийн баримт, төлбөрийн даалгаврыг баталгаажуулах;
- санхүүгийн үйл ажиллагааг шалгах;

- жилийн санхүүгийн тайланг баталгаажуулах;
- санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой зөрчил, албан үүргийн биелэлтийг шалгах;
- санхүүгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэх;
- санхүүгийн хариуцлагыг шүүх (to judge);
- бусад хуульд заасан аудитын бусад ажлыг гүйцэтгэх.

Аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу аудитор зөрчил, албан үүргээ биелүүлээгүйг илрүүлсэн бол холбогдох аудитын байгууллагад мэдэгдэнэ. Мөн шаардлагатай арга хэмжээ авахыг холбогдох байгууллагад мэдэгдэж, хуулийн дагуу арга хэмжээ авах талаар Хяналтын Юанд тайлагнана. Эрүүгийн гэмт хэргийн шинжтэй хэргийг шүүхэд шилжүүлж, Хяналтын Юанд мэдэгдэнэ.

Аудитын тухай хуульд аудиторуд ажил үүргээ бие даан, хөндлөнгийн оролцоогүйгээр гүйцэтгэх, аудитын байгууллага эрх, үүргээ хэрэгжүүлэхийн тулд аудиторудад төрөл бүрийн байгууллагад тогтмол болон түр хугацаагаар томилон ажиллуулж байхаар заасан. Аудитын байгууллага нь тухайн байгууллага руу аудиторудад томилоогүй тохиолдолд холбогдох бичиг баримтыг бүрдүүлж, санамсаргүй хяналт шалгалтад хамруулахыг шаардаж болно.

Аудитын байгууллага нь төрийн байгууллагын төлбөрийн баримт, санхүүгийн баримт, эд хөрөнгийг хүссэн үедээ шалгаж болно. Аудиторуд ном, эрхийн бичиг, бусад баримт бичиг, бэлэн мөнгө, эд хөрөнгөд үзлэг хийхийг шаардсан тохиолдолд тухайн байгууллагын хариуцсан ажилтан нь нуух, хүлээлгэн өгөхөөс татгалзах ёсгүй. Тэд аудитын асуултанд дэлгэрэнгүй хариулж, шаардлагатай бол холбогдох материалыг гаргаж өгнө.

Аудиторуд байгууллагын албан тушаалтнуудын санхүүгийн зөрчил, шударга бус үйлдэл илрүүлсэн тохиолдолд аудитын эрх бүхий байгууллагад мэдээлж, арга хэмжээ авах талаар байгууллагын даргад мэдэгдэнэ. Түүнчлэн хуулийн дагуу хэргийг хянан шийдвэрлэхийн тулд аудитын байгууллагаар дамжуулан Хяналтын Юанд тайлагнаж болно. Хэрэв хэрэг үйлдсэн бол шүүхийн байгууллагад шилжүүлж, Хяналтын Юанд мэдэгдэнэ.

Аудитын байгууллага нь үр ашиггүй, эсхүл чиг үүргээ хэрэгжүүлэхгүй байгаа байгууллагыг илрүүлсэн бол тухайн байгууллагыг холбогдох хяналтын байгууллагад нь мэдэгдэхээс гадна Хяналтын Юанд мэдэгдэнэ. Хэрэв уг асуудал нь системийн зохицуулалтын дутагдал, эсхүл хүлээн зөвшөөрөгдөөгүй байгууламжаас шалтгаалсан бол сайжруулах тухай санал гаргах эрхтэй.



Source: NAO 2020 Annual Report, p.13

Хүний эрхийн үндэсний комиссын үйл ажиллагаа

Хяналтын Юаны Хүний эрхийн үндэсний комиссын тухай органик хууль (Organic Act of the Control Yuan National Human Rights Commission)-ийн 2 дугаар зүйлд заасны дагуу Хүний эрхийн үндэсний комисс (ХЭҮК) дараах чиг үүрэг, бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- эрүү шүүлт, хүний эрхийг зөрчих, ялгаварлан гадуурхах зэрэг янз бүрийн хэлбэрээр гарсан зөрчлийг өөрийн эрх мэдлийн дагуу буюу олон нийтээс ирүүлсэн өргөдлийн дагуу шалгах, хуулийн дагуу шийдвэрлэж арилгах;
- хүний эрхийн талаарх үндэсний бодлогыг судлах, дүгнэлт, зөвлөмж гаргах;
- хүний эрхийн дотоодын нөхцөл байдлыг судалж, үнэлэх зорилгоор хүний эрхийн гол асуудлаар сэдэвчилсэн илтгэл, эсхүл хүний эрхийн байдлын талаарх жилийн тайланг гаргах;

- хүний эрхийн олон улсын баримт бичигт гарын үсэг зурах, соёрхон батлах, тэдгээрийг нэгтгэхэд төрийн байгууллагуудад туслалцаа үзүүлэх, дотоодын хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, захиргааны арга хэмжээг олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэн хангах;
- Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахад шаардлагатай, хэрэгжих боломжтой зөвлөмж гаргах зорилгоор Үндсэн хууль, эрх зүйн актуудыг хүний эрхийн олон улсын жишигт тулгуурлан системчилсэн судалгаа хийх;
- хүний эрхийн боловсролыг дэмжих, хүний эрхийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, хүний эрхийн асуудалд төрийн байгууллагуудын үр нөлөөг хянах;
- хүний эрхийг хамгаалах чиглэлээр дотоодын байгууллага, олон нийтийн бүлгүүд, олон улсын байгууллага, хүний эрхийн үндэсний хүрээлэн, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;
- хүний эрхийн олон улсын гэрээний заалтын дагуу Засгийн газраас өргөн мэдүүлсэн үндэсний тайланд бие даасан дүгнэлт гаргах;
- хүний эрхийг хамгаалах, дэмжихтэй холбогдсон бусад асуудал.

ХЭҮК нь Хяналтын Юаны Ерөнхийлөгчийн хамт 10 гишүүнээс бүрдэнэ. Хяналтын Юаны тухай органик хуулийн 3-1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасан “нэр хүндтэй хүний эрхийг хамгаалах чиглэлийн судлаач, эсхүл хүний эрхийг хамгаалагч, эсхүл иргэний нийгмийн байгууллагад хүний эрхийг хамгаалах, дэмжих чиглэлээр ажиллаж байсан туршлагатай” гишүүний тоо 7 байна.

ХЭҮК-ыг Хяналтын Юаны Ерөнхийлөгч удирдах ба дэд даргыг ХЭҮК-ын гишүүдээс сонгодог.



ХАВСРАЛТУУД

Албан бус орчуулга

Хавсралт 1. Тайванийн Үндсэн хуулийн Хяналтын Юантай холбоотой зохицуулалт

60 дугаар зүйл. Гүйцэтгэх Юан (Executive Yuan) санхүүгийн жил бүр дууссанаас хойш дөрвөн сарын дотор орлого, зарлагын эцсийн тайлангаа Хяналтын Юанд танилцуулна.

79 дүгээр зүйл. Шүүх Юан (Judicial Yuan) нь Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгчтэй байх ба тэднийг Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нэр дэвшүүлж, Хяналтын Юанын зөвшөөрснөөр томилно.

Шүүх Юан энэ Үндсэн хуулийн 78 дугаар зүйлд заасан асуудлыг хариуцах тодорхой тооны шүүгчтэй байх бөгөөд шүүгчдийг Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нэр дэвшүүлж, Хяналтын Юанын зөвшөөрснөөр томилно.

84 дүгээр зүйл. Шалгалтын Юан (Examination Yuan) нь Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, тодорхой тооны гишүүдтэй байх ба тэднийг Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нэр дэвшүүлж, Хяналтын Юанын зөвшөөрснөөр томилно.

115 дугаар зүйл. Хэрэв Мужийн өөрөө удирдах ёсны дүрэм (the Provincial Self-Government Regulations)-ийг хэрэгжүүлэх явцад түүнд тусгагдсан аливаа заалтыг хэрэгжүүлэхэд ноцтой саад бэрхшээл тулгарвал Шүүхийн Юан эхлээд холбогдох талуудыг дуудаж санал бодлоо илэрхийлнэ. Үүний дараа Гүйцэтгэх Юан, Хууль тогтоох Юан, Шүүх Юан, Шалгалтын Юан, Хяналтын Юанын Ерөнхийлөгч нар Шүүх Юанын Ерөнхийлөгчөөр удирдуулсан хороо байгуулж, уг асуудлыг шийдвэрлэх томъёолол санал болгоно.

IX БҮЛЭГ. ХЯНАЛТ

90 дүгээр зүйл. Хяналтын Юан (Control Yuan – хяналтын эрх мэдэл) нь төрийн хяналтын эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллага ба зөрчил арилгах арга хэмжээ авах, итгэл үзүүлэх эсэх, хариуцлага тооцох, аудит хийх эрх мэдлийг хэрэгжүүлнэ.

91 дүгээр зүйл. Хяналтын Юаныг аймгийн болон хотын зөвлөл, Монголын болон Төвдийн орон нутгийн зөвлөл (the local Councils of Mongolia and Tibet), мөн гадаад улсад оршин суугаа Бүгд Найрамдах Хятад Улс (БНХУ, Republic of China)-ын иргэдээс сонгосон гишүүдээс бүрдэнэ. Гишүүдийн тоог дараах байдлаар тогтооно:

1. аймаг тус бүрээс таван гишүүн;
2. Гүйцэтгэх Юан (Executive Yuan – гүйцэтгэх эрх мэдэл)-д шууд харьяалагддаг хот тус бүрээс хоёр гишүүн;
3. Монголын хошуу болон аймаг (Mongolian Leagues and Banners)-аас найман гишүүн;
4. Төвдөөс найман гишүүн;
5. гадаад улсад оршин суугаа БНХУ-ын иргэдээс найман гишүүн.

92 дугаар зүйл. Хяналтын Юан нь гишүүдээсээ сонгосон Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгчтэй байна.

93 дугаар зүйл. Хяналтын Юаны гишүүн зургаан жилийн хугацаатай сонгогдох ба дахин сонгогдож болно.

94 дүгээр зүйл. Хяналтын Юан нь энэхүү Үндсэн хуульд заасны дагуу зөрчил арилгах арга хэмжээ авах эрхээ хэрэгжүүлэхдээ хуралдаанд оролцсон гишүүдийн олонхоор шийдвэрлэнэ.

95 дугаар зүйл. Хяналтын Юан нь хяналтын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Гүйцэтгэх Юан, түүний яамд болон хороодоос гаргасан тушаалын эх хувь болон холбогдох бусад бүх баримт бичгийг авахаар шаардаж болно.

96 дугаар зүйл. Хяналтын Юан нь Гүйцэтгэх Юан, түүний яамд болон хороодын үйл ажиллагааны хүрээг харгалзан, тэдний хууль зөрчсөн, эсхүл албан үүрэгтээ хайхрамжгүй хандсан гэм буруутай эсэхийг тогтоох зорилгоор тэдний үйл ажиллагааг мөрдөн шалгахын тулд хороо байгуулж болно.

97 дугаар зүйл. Хяналтын Юан нь өөрийн хороодын мөрдөн шалгалт, шийдвэрийн үндсэн дээр зөрчил арилгах арга хэмжээний саналыг Гүйцэтгэх Юан, холбогдох яамд болон хороодод хүргүүлэх ба сайжруулахад чиглэсэн арга хэмжээнд хяналт тавьж болно. Хяналтын Юан нь Төв Засгийн газар, эсхүл орон нутгийн засаг захиргааны төрийн албан хаагчийг хууль зөрчсөн, эсхүл албан үүрэгтээ хайхрамжгүй хандсан гэм буруутай гэж үзвэл зөрчил арилгах арга хэмжээ авах, эсхүл итгэл үзүүлэх эсэх талаар санал гаргаж болно. Хэрэв эрүүгийн гэмт хэргийн шинжтэй бол уг хэргийг шүүхэд шилжүүлнэ.

98 дугаар зүйл. Төв Засгийн газар, эсхүл орон нутгийн засаг захиргааны төрийн албан хаагчид итгэл үзүүлэх эсэх асуудлыг Хяналтын Юаны есөөс доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй хорооны нэг буюу түүнээс дээш гишүүн санал болгож, журмын дагуу хэлэлцэж шийдвэрлэсний үндсэн дээр Хяналтын Юан хэлэлцэнэ.

99 дүгээр зүйл. Хяналтын Юанаас Шүүхийн Юан (Judicial Yuan) болон Шалгалтын Юан (Examination Yuan)-ын албан хаагчдыг хууль зөрчсөн, эсхүл албан үүрэгтээ хайхрамжгүй хандсан гэх үндэслэлээр итгэл үзүүлээгүй бол энэхүү Үндсэн хуулийн 95, 97, 98 дугаар зүйлд заасан заалтыг мөрдөнө.

100 дугаар зүйл. Хяналтын Юанд Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч болон Дэд Ерөнхийлөгчид итгэл үзүүлэх эсэх асуудлыг Хяналтын Юаны бүх гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь санал болгож, журмын дагуу хэлэлцсэний дараа олонхын саналаар шийдвэрлэнэ. Хяналтын Юаны нийт гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэж, Үндэсний Ассамблейд өргөн мэдүүлнэ.

101 дүгээр зүйл. Хяналтын Юаны гишүүн Юанд хэлсэн үг, өгсөн саналын хариуцлагыг Юанаас гадуур хүлээхгүй.

102 дугаар зүйл. Хяналтын Юаны гишүүнийг гэмт хэргийн газарт баривчлахаас бусад тохиолдолд Хяналтын Юаны зөвшөөрөлгүйгээр баривчлах, эсхүл албадан саатуулахыг хориглоно.

103 дугаар зүйл. Хяналтын Юаны гишүүн төрийн албанд, эсхүл өөр мэргэжлээр хавсран ажиллаж болохгүй.

104 дүгээр зүйл. Хяналтын Юан нь Ерөнхий аудитортай байх ба түүнийг Хууль тогтоох Юан (Legislative Yuan)-ын зөвшөөрснөөр Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч томилно.

105 дугаар зүйл. Ерөнхий аудитор нь Гүйцэтгэх Юанаас орлого, зарлагын эцсийн тайланг ирүүлснээс хойш гурван сарын дотор хуульд заасан журмын дагуу аудит хийж, тайланг Хууль тогтоох Юанд хүргүүлнэ.

106 дугаар зүйл. Хяналтын Юаны зохион байгуулалтыг хуулиар тогтооно.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

Албан бус орчуулга**Хавсралт 2. Тайванийн Хяналтын Юаны тухай хууль**

1 дүгээр зүйл. Энэ хуулийг Үндсэн хуулийн 106 дугаар зүйлд заасны дагуу баталсан.

2 дугаар зүйл. Хяналтын Юан нь Үндсэн хуульд заасан чиг үүрэг, бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

3 дугаар зүйл. Хяналтын Юан нь тусдаа хороод байгуулж болох бөгөөд тэдгээрийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

Хяналтын Юан нь Хүний эрхийн үндэсний комиссыг байгуулах бөгөөд түүний эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

3-1 дүгээр зүйл. Хяналтын Юаны гишүүд нь 35-аас доошгүй настай байх ба дор дурдсан шалгууруудын аль нэгийг хангасан байна:

- 1) хууль тогтоох байгууллагын гишүүнээр 1-ээс доошгүй удаа, эсхүл хотын тусгай зөвлөлийн гишүүнээр 2-оос доошгүй удаа сонгогдож, нэр хүндтэй ажиллаж байсан;
- 2) 12-оос доошгүй түвшний шүүгч, прокуророор 10-аас доошгүй жил, мөн Дээд шүүх, Захиргааны хэргийн дээд шүүх, Дээд шүүхийн Прокурорын газар болон түүнээс дээш шатны шүүхийн шүүгч, прокуророор нэр хүндтэй ажиллаж байсан;
- 3) Сонгогдсон зэрэг (Selected Rank)-т төрийн албан хаагчаар 10-аас доошгүй жил нэр хүндтэй ажиллаж байсан;
- 4) их сургуулийн профессороор 10-аас доошгүй жил нэр хүндтэй ажиллаж байсан;
- 5) дотоодын Мэргэжлийн болон Техникийн ахисан түвшний шалгалт (Professional and Technical Senior Examination)-ын дагуу мэргэшсэн, мэргэжлээрээ 15-аас доошгүй жил нэр хүндтэй ажиллаж байсан;
- 6) улс төрийн арвин туршлагатай, эсхүл сэтгүүл зүй, соёлын үйл ажиллагааг удирдаж байсан туршлагатай, нэр хүндтэй, шударга, ухамсартай хүн;
- 7) нэр хүндтэй хүний эрхийг хамгаалах чиглэлийн судлаач, эсхүл хүний эрхийг хамгаалагч, эсхүл иргэний нийгмийн байгууллагад хүний эрхийг хамгаалах, дэмжих чиглэлээр ажиллаж байсан туршлагатай хүн.

Дээрх жагсаалтын 7-д заасан шаардлагыг хангасан гишүүний тоо долоо байх ба сул орон тоо байх ёсгүй. Хяналтын Юаны бүрэлдэхүүн нь өөр үндэстэн ястан, мэргэжил зэрэг олон талын төлөөллийг багтаасан

байна. Аль нэг хүйсийн төлөөлөл гишүүдийн гуравны нэгээс бага хувийг эзлэх ёсгүй. Гишүүнд нэр дэвшүүлэхээс өмнө иргэний нийгмийн байгууллагуудын саналыг нээлттэй авна.

Дээрх жагсаалтын 1-т заасан албан тушаал хашсан хугацааг Хяналтын Юаны гишүүний дараагийн хугацаа эхлэхийн өмнөх өдөр хүртэл тооцно.

4 дүгээр зүйл. Хяналтын Юан нь дараах асуудлуудыг хариуцах Үндэсний аудитын газрыг байгуулна:

- 1) Засгийн газрын бүх шатны төсвийн гүйцэтгэлд хяналт тавих;
- 2) төрийн бүх шатны байгууллагын орлого, төлбөрийн даалгаврыг баталгаажуулах;
- 3) Засгийн газрын бүх шатны байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг шалгах, жилийн санхүүгийн тайланг баталгаажуулах;
- 4) төрийн бүх шатны байгууллагын санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой хууль бус байдал, албан үүргийн хариуцлагаа алдсан байдлыг шалгах;
- 5) Засгийн газрын бүх шатны байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд үнэлгээ хийх;
- 6) төрийн байгууллагын ажилтны санхүүгийн үүрэг хариуцлагыг батлах;
- 7) бусад хуульд заасан аудитын бусад чиг үүргийг гүйцэтгэх.

Үндэсний аудитын газрын эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

5 дугаар зүйл. Ерөнхий аудитор нь Үндэсний аудитын газрын үйл ажиллагаанд хяналт тавина.

6 дугаар зүйл. Хяналтын Юаны Ерөнхийлөгч нь Юаны үйл ажиллагаанд болон харьяа агентлагуудад хяналт тавина. Хэрэв Ерөнхийлөгч ямар нэг шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон бол Дэд Ерөнхийлөгч түүний нэрийн өмнөөс гүйцэтгэнэ.

Хэрэв Хяналтын Юаны Ерөнхийлөгчийн орон сул байгаа бол Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь дараагийн Ерөнхийлөгчийг нэр дэвшүүлж, Хууль тогтоох Юан (Legislative Yuan)-ы зөвшөөрснөөр томилох хүртэл Дэд Ерөнхийлөгч уг албан үүргийг орлон гүйцэтгэнэ.

Хэрэв Хяналтын Юаны Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгчийн орон нэгэн зэрэг сул байгаа бол Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь тэднийг нэр дэвшүүлж, Хууль тогтоох Юан (Legislative Yuan)-ы зөвшөөрснөөр томилох хүртэл Хяналтын Юаны нэг гишүүнийг орлон гүйцэтгэгчээр томилно.

Хэрэв Хяналтын Юаны Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, гишүүний орон сул байгаа бол тэдний залгамжлагчдын бүрэн эрхийн хугацаа нь орон гарсан бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.

7 дугаар зүйл. Хяналтын Юаны хуралдааныг Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, Хяналтын Юаны гишүүд зохион байгуулах ба Ерөнхийлөгч хуралдааныг даргална.

8 дугаар зүйл. Хяналтын Юан нь бодит хэрэгцээнд нийцүүлэн Хяналтын Юаны гишүүдэд зориулсан дүүргийн захиргааны албыг улсын хэмжээнд байгуулж болно. Тэдгээрийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

9 дүгээр зүйл. Хяналтын Юан нь Юаны Ерөнхийлөгчийн зарлигаар Юаны өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, ажилтнуудыг удирдан чиглүүлэх/хянах үүрэгтэй тусгайлан томилогдсон ерөнхий нарийн бичгийн даргатай байна. Ерөнхий нарийн бичгийн дарга нь Юаны Ерөнхийлөгчийн зарлигаар томилогдсон Сонгогдсон зэрэг (the Selected Rank)-ийн 14 дүгээр түвшний нэг орлогчтой байна.

10 дугаар зүйл. Хяналтын Юан нь дор дурдсан асуудлуудыг хариуцах Хяналтын үйл ажиллагааны газар, Мөрдөн шалгах газар, Төрийн албан хаагчдын өмч хөрөнгийн мэдүүлгийн газар, Тамгын газар, Зохицуулалт, төлөвлөлтийн газрыг байгуулна. Газар бүр хэлтэс, эсхүл хэсгүүдэд хуваагдаж болно:

- 1) иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах, боловсруулах, санал гаргахтай холбоотой асуудал;
- 2) хариуцлага тооцох асуудал;
- 3) хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа;
- 4) төрийн албан хаагчдын эд хөрөнгийн мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчлийн улмаас эргүүлэн татах, улс төрийн хандив, лоббитой холбоотой асуудал;
- 5) хуралдааны тэмдэглэл хөтлөх, олон нийтэд зориулсан тайланг эмхэтгэн хэвлэхтэй холбоотой асуудал;
- 6) баримт бичиг хүлээн авах, олгох, тамга тэмдэг хадгалахтай холбоотой асуудал;
- 7) улсын төсөв болон үйл ажиллагаатай холбоотой ерөнхий асуудал;
- 8) нэгдсэн төлөвлөгөө, судалгаа боловсруулах, хөгжүүлэх, үнэлгээ хийх асуудал;
- 9) мэдээллийн төлөвлөлт, систем, тоног төхөөрөмж, аюулгүй байдал, сургалтын ерөнхий төлөвлөгөө болон удирдлагатай холбоотой асуудал;
- 10) зохицуулалт, харилцаа холбоо, мэдээ мэдээлэлтэй холбоотой асуудал;
- 11) холбогдох бусад асуудал.

11 дүгээр зүйл. (Хүчингүй болсон)

12 дугаар зүйл. Хяналтын Юан нь Сонгогдсон зэрэг (the Selected Rank)-ийн 12-13 дугаар түвшний хоёроос дөрвөн зөвлөх, таван хэлтсийн дарга; Сонгогдсон зэргийн 11-12 дугаар түвшний хэлтсийн даргын таван орлогч; Сонгогдсон зэргийн 10-12 дугаар түвшний 24-28 мөрдөн байцаагч; мөрдөн байцаагчийн албан үүргийг хавсран гүйцэтгэх мөрдөн байцаах хэсгийн найман дарга; Сонгогдсон зэргийн 10-11 дүгээр түвшний Гомдол хүлээн авах төв (Complaint Receipt Center)-ийн нэг дарга, 11 хэсгийн ахлагч, дөрвөн ахлах мэргэжилтэн, нэг системийн ахлах шинжээч; Дэвшүүлэн томилсон зэрэг (the Recommended Rank)-ийн 8-9 дүгээр түвшний 26-31 нарийн бичгийн дарга, тэдний 11 нь Сонгогдсон зэргийн 10-12 дугаар түвшнийх байж болно; Дэвшүүлэн томилсон зэргийн 9 дүгээр түвшний 11 хэсгийн ахлагч; Дэвшүүлэн томилсон зэргийн 8-9 дүгээр түвшний 24-28 ахлах мөрдөн байцаагч; Дэвшүүлэн томилсон зэргийн 7-9 дүгээр түвшний 10-16 мэргэжилтэн, хоёр системийн шинжээч; Дэвшүүлэн томилсон зэргийн 6-8 дугаар түвшний хоёр системийн дизайнер, нэг системийн зохицуулагч; Томилогдсон зэрэг (Designated Rank)-ийн 5 дугаар түвшний, эсхүл Дэвшүүлэн томилсон зэргийн 6-7 дугаар түвшний 24-28 мөрдөн байцаагч, 20-28 алба хаагч, 2-4 стенографич; Томилогдсон зэргийн 4-5 дугаар түвшний дөрвөөс найман туслах албан хаагч, хоёр оператор, тэдний дөрвөн туслах албан хаагч, нэг оператор нь Дэвшүүлэн томилсон зэргийн 6 дугаар түвшнийх байж болно; Томилогдсон зэргийн 3-5 дугаар түвшний 10-18 бичиг хэргийн ажилтан; Томилогдсон зэргийн 1-3 дугаар түвшний долоон туслах ажилтан; Эмнэлгийн ажилтны Гуравдугаар зэргийн нэг эм зүйч, хоёр сувилагчтай байна.

13 дугаар зүйл. Хяналтын Юан нь хуулийн дагуу төсөв, нягтлан бодох бүртгэл, статистик, хүний нөөц, ёс зүйн асуудлаарх чиг үүргийг гүйцэтгэх Нягтлан бодох бүртгэлийн алба, Статистикийн алба, Боловсон хүчний алба, Ёс зүйн албыг тус тус байгуулна.

Нягтлан бодох бүртгэлийн алба, Статистикийн алба, Боловсон хүчний алба, Ёс зүйн алба тус бүр Сонгогдсон зэргийн 10-11 дүгээр түвшний нэг захиралтай байна. Шаардлагатай бол хуульд заасан квотын хүрээнд албан хаагчдыг нэмж томилж болно.

13-1 дүгээр зүйл. Хяналтын Юаны гишүүн бүр сонгогдсон хугацаатайгаа ижил хугацаанд нэг туслах томилно.

14 дүгээр зүйл. Хяналтын Юаны хуралдааны болон Хяналтын хэлтсийн ажлын журмыг Хяналтын Юан тогтооно.

15 дугаар зүйл. Энэ хуулийг нийтлэгдсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Энэ хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн заалтуудыг нийтлэгдсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Албан бус орчуулга**Хавсралт 3. Тайванийн Хяналтын тухай хууль¹⁸⁶****I БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1 дүгээр зүйл. Хяналтын Юан (Control Yuan – хяналтын эрх мэдэл) нь Үндсэн хууль болон Үндсэн хуулийн нэмэлт заалт (Additional Articles of the Constitution)-д заасны дагуу итгэл үзүүлэх эсэх (impeachment), хариуцлага тооцох, аудит хийх бүрэн эрхийг хэрэгжүүлэх ба зөрчил арилгах арга хэмжээ санал болгоно. Аудитаас бусад бүрэн эрхийг энэ хуулийн дагуу хэрэгжүүлнэ.

2 дугаар зүйл. Хяналтын Юаны гишүүн нь итгэл үзүүлэх эсэх, хариуцлага тооцох эрх мэдлийг хэрэгжүүлнэ. Хяналтын Юаны хороод нь зөрчил арилгах арга хэмжээг санал болгоно.

3 дугаар зүйл. Хяналтын Юаны гишүүд бүхий л нутаг дэвсгэрт аливаа салбар чиглэлээр хяналт тавьж болно.

4 дүгээр зүйл. Хяналтын Юан болон түүний гишүүд иргэдээс гомдлыг бичгээр хүлээн авч болно. Хяналтын Юан энэ талаар журам тогтооно.

II БҮЛЭГ. ИТГЭЛ ҮЗҮҮЛЭХ ЭСЭХ

5 дугаар зүйл. (Хүчингүй болсон)

6 дугаар зүйл. Хяналтын Юаны хоёроос доошгүй гишүүн санал болгосноор Хяналтын Юаны гишүүд хууль зөрчсөн, албан үүргээ биелүүлээгүй гэж үзсэн тохиолдолд төрийн албан хаагчид хариуцлага тооцно.

7 дугаар зүйл. Итгэл үзүүлэх эсэх асуудлыг бичгээр дэлгэрэнгүй санал болгоно. Санал гаргасан гишүүд уг асуудлыг хянан шалгах аас өмнө нэмэлт мэдээлэл хийж болно.

8 дугаар зүйл. Санал гаргасан гишүүдийг оролцуулахгүйгээр ес буюу түүнээс дээш гишүүн хянан шалгаад хариуцлага тооцох ёстой гэж үзвэл Хяналтын Юан уг асуудлыг шийдвэрлүүлэхээр эрх бүхий сахилгын байгууллага (disciplinary organ)-д шилжүүлнэ. Хэрэв шинэ баримт, эсхүл нотлох баримт илэрсэн бол түүнийг хянан шалгасны дараа сахилгын байгууллагад шилжүүлнэ.

Итгэл үзүүлэх эсэх асуудлын талаарх шалгалтын хорооны шийдвэрийг гарын үсэг зурж санал хураах ба олонхын саналаар шийдвэрлэнэ.

¹⁸⁶ Control Act. Announced Date: 1947-01-01. <https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=A0030199>

9 дүгээр зүйл. Итгэл үзүүлэх эсэх асуудлаар хянан шалгах ажлыг Хяналтын Юаны бүх гишүүд ээлжлэн явуулна.

10 дугаар зүйл. Хэрэв хянан шалгах явцад итгэл үзүүлэх эсэх хэрэг нь үндэслэлгүй гэж үзэж, санал гаргасан гишүүд энэ шийдвэрийг эсэргүүцсэн бол уг асуудлыг эцэслэн шийдвэрлэхийн тулд Хяналтын Юаны бусад ес буюу түүнээс дээш гишүүн дахин хянан шалгана.

11 дүгээр зүйл. Итгэл үзүүлэх эсэх хэрэгт оролцсон Хяналтын Юаны гишүүд уг хэргийг хэлэлцэхэд оролцохгүй.

12 дугаар зүйл. Хяналтын Юаны Ерөнхийлөгч нь аливаа тохиолдолд итгэл үзүүлэх эсэх асуудалд нөлөөлөх, хөндлөнгөөс оролцохгүй.

13 дугаар зүйл. Хяналтын Юаны гишүүд болон түүний ажилтнууд хяналт шалгалтын дүгнэлт гарахаас өмнө итгэл үзүүлэх эсэх асуудлын талаар олон нийтэд мэдээлэхгүй.

Хяналтын Юан нь итгэл үзүүлэх эсэх хэргийн хяналт шалгалтын дүгнэлтийг олон нийтэд мэдээлнэ. Хэрэв уг хэрэг нь үндэсний аюулгүй байдал, дипломат харилцаа, эсхүл хуулиар нууцад хамруулсан бусад салбартай холбоотой бол уг нууц мэдээллийг хянан засварласны дараа олон нийтэд мэдээлнэ.

14 дүгээр зүйл. Хяналтын Юан итгэл үзүүлэх эсэх хэргийг сахилгын байгууллагад шилжүүлэх үед тухайн хэрэг нь хууль зөрчсөн, эсхүл албан үүргээ биелүүлээгүйн улмаас нэн даруй зөрчил арилгах арга хэмжээ авахаар хангалттай ноцтой гэж үзвэл, Хяналтын Юанаас гэм буруутай этгээдийн удирдах албан тушаалтан, эсхүл зөрчил арилгах арга хэмжээ авах эрх бүхий албан тушаалтанд тухайн зөрчлийг арилгах арга хэмжээ нэн даруй авахыг мэдэгдэнэ.

Удирдах албан тушаалтан нь ийнхүү мэдэгдэл авсан боловч гэм буруутай этгээдэд зохих хариуцлага тооцоогүй бол түүнийг албан үүргээ биелүүлээгүй гэм буруутайд тооцно.

15 дугаар зүйл. Хэрэв Хяналтын Юан итгэл үзүүлэх эсэхийг нь хөндсөн төрийн албан хаагчийг эрүүгийн, эсхүл цэргийн хууль тогтоомжийг зөрчсөн гэж үзвэл, Хяналтын Юан уг хэргийг сахилгын байгууллагад шилжүүлэхээс гадна эрх бүхий шүүх, эсхүл цэргийн шүүхэд хуулийн дагуу арга хэмжээ авахуулахаар шилжүүлнэ.

16 дугаар зүйл. Итгэл үзүүлэх эсэх хэргийг сахилгын байгууллага болон ерөнхий харьяаллын шүүх, эсхүл цэргийн шүүхэд шилжүүлсэн бол эрх бүхий байгууллагууд яаралтай арга хэмжээ авч, авсан арга хэмжээний талаар Хяналтын Юанаар дамжуулан санал гаргасан гишүүдэд нэн даруй мэдэгдэнэ.

Итгэл үзүүлэх эсэхийг нь хөндсөн төрийн албан хаагчийг өмгөөлсөн аливаа мэдэгдлийг Хяналтын Юанаар дамжуулан санал гаргасан гишүүдэд нэн даруй хүргүүлнэ. Санал гаргасан гишүүд мэдэгдэл хүлээн авснаас хойш арав хоногийн дотор санал, дүгнэлтээ сахилгын байгууллагад хүргүүлж болно.

17 дугаар зүйл. (Хүчингүй болсон)

18 дугаар зүйл. Итгэл үзүүлэх эсэхээс болж хариуцлага хүлээсэн этгээд албан үүргээс нь түдгэлзүүлсэн хугацаанд төрийн аливаа байгууллагад ажилд орохыг хориглоно.

Хариуцлага тооцох тухай шийдвэр гарснаар тухайн этгээдийн хууль ёсны урамшуулал нь хариуцлага хүлээх хугацаанд хүчингүй болно. Хэрэв тухайн этгээд сануулах арга хэмжээ авсан бол түүний урамшуулал нь хүчинтэй хэвээр байна.

III БҮЛЭГ. ХАРИУЦЛАГА ТООЦОХ

19 дүгээр зүйл. Хяналтын Юаны гишүүн нь төрийн албан хаагчийг хууль зөрчсөн, эсхүл албан үүргээ биелүүлээгүйн улмаас албан үүргээс нь түдгэлзүүлэх, эсхүл нэн даруй зөрчил арилгах арга хэмжээ авах шаардлагатай гэж үзсэн бол хариуцлага тооцож болох ба үүнийг Хяналтын Юаны бусад гурав буюу түүнээс дээш гишүүн хянан шийдвэрлэнэ. Хяналтын Юан хариуцлага тооцох хэргийг тухайн төрийн албан хаагчийн удирдах, эсхүл эрх бүхий албан тушаалтанд илгээнэ. Хэрэв уг хэрэг нь эрүүгийн, эсхүл цэргийн хууль тогтоомж зөрчсөн гэж үзвэл уг хэргийг эрх бүхий шүүх, эсхүл цэргийн шүүхэд шилжүүлнэ.

Хяналтын Юаны гишүүн нь өөрийн хянах үүрэгтэй албан тушаалын зэргээс доогуур төрийн албан хаагчид хариуцлага тооцох хэргийг бичгээр хүргүүлэх бол тухайн албан тушаалтны удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэнэ.

20 дугаар зүйл. Хэрэв хариуцлага тооцох хэргийг үндэслэлгүй гэж үзэж, санал гаргасан гишүүд энэ шийдвэртэй санал нийлэхгүй бол Хяналтын Юаны бусад гурав буюу түүнээс дээш гишүүн дахин хянан шалгаж эцсийн шийдвэрийг гаргана.

21 дүгээр зүйл. Эрх бүхий шүүх, эсхүл цэргийн шүүхээр тусад нь хянан шийдвэрлэх эрүүгийн, эсхүл цэргийн хууль тогтоомж зөрчсөнтэй холбоотой хэргээс бусад тохиолдолд төрийн албан хаагчид хариуцлага тооцохыг эсэргүүцсэний дараа түүний удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий албан тушаалтан нь Төрийн албан хаагчдад сахилгын шийтгэл ногдуулах тухай хууль (Law of Discipline Against Public Functionaries)-ийн

дагуу нэг сарын дотор уг хэргийг авч хэлэлцэнэ. Тэрээр хариуцлага тооцуулсан албан тушаалтныг албан үүргээс нь түдгэлзүүлж болно. Хэрэв удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий албан тушаалтан нь тухайн этгээдэд хариуцлага тооцох шаардлагагүй гэж үзвэл үндэслэлээ Хяналтын Юанд мэдэгдэнэ.

22 дугаар зүйл. Удирдах, эсхүл эрх бүхий албан тушаалтан нь өмнөх зүйлд заасны дагуу хариуцлага тооцсон хэргийг авч хэлэлцээгүй, эсхүл авсан арга хэмжээг нь Хяналтын Юаны хоёр буюу түүнээс дээш гишүүн тохирохгүй гэж үзсэн бол хариуцлага тооцуулсан төрийн албан хаагчид итгэл үзүүлэх эсэх асуудлыг хөндөнө.

Хариуцлага тооцуулсан төрийн албан хаагчийн удирдах, эсхүл эрх бүхий албан тушаалтан хариуцлага тооцсон тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш түүнд хариуцлага тооцоогүй, эсхүл хариуцлага тооцохгүй гэж шийдвэрлэсэн бол хариуцлага тооцуулсан төрийн албан хаагчид итгэл үзүүлэхгүй байх, удирдах, эсхүл эрх бүхий албан тушаалтанд албан үүргээ биелүүлээгүй гэсэн үндэслэлээр тус тус хариуцлага тооцно.

23 дугаар зүйл. Хариуцлага тооцсон хэрэгт энэ хуулийн 8, 11, 12, 13, 16 дугаар зүйлийг зайлшгүй өөрчлөлтүүдтэй хэрэглэнэ.

IV БҮЛЭГ. ЗӨРЧИЛ АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ

24 дүгээр зүйл. Хяналтын Юан нь Гүйцэтгэх Юан болон түүний харьяа байгууллагуудын ажил, чадавхыг мөрдөн шалгасны дараа холбогдох хороод зөрчил арилгах арга хэмжээнүүдийг хянан шалгаж, баталсны дараа Гүйцэтгэх Юан болон түүний харьяа байгууллагуудад тэдгээрийг санал болгож болно.

25 дугаар зүйл. Гүйцэтгэх Юан, эсхүл түүний харьяа яамд, хороод зөрчил арилгах арга хэмжээний талаар мэдэгдэл авсан даруйдаа сайжруулах буюу зохих арга хэмжээг авч, сайжруулсан, авсан арга хэмжээнийхээ талаар Хяналтын Юанд бичгээр хариу өгнө. Хэрэв Хяналтын Юан хоёр сарын дотор хариу аваагүй бол холбогдох байгууллагад хандаж болно.

V БҮЛЭГ. МӨРДӨН ШАЛГАХ

26 дугаар зүйл. Хяналтын бүрэн эрхээ хэрэгжүүлэхийн тулд хяналтын гэрчилгээтэй Хяналтын Юаны гишүүн, эсхүл Хяналтын Юанаас томилсон шалгалтын гэрчилгээтэй ажилтан нь төрийн болон хувийн хэвшлийн байгууллага дээр очиж, хавтаст хэрэг, бүртгэл, холбогдох баримт бичгийг шалгаж болно. Эдгээр байгууллагын дарга, холбогдох бусад ажилтнууд шалгуулах ба байцаалт авахад дэлгэрэнгүй хариулт өгч, байцаалтын тэмдэглэлд гарын үсгээ зурна.

Шалгагч хэргийг шалгахдаа энэ тухай бичгээр гомдол гаргаж гарын үсэг зурсан этгээдэд мэдэгдэх ба шалгагдаж байгаа этгээдийг тогтоосон газарт дуудан байцаалт авч болно.

Шалгагч хэргийн агуулгыг нийтэд мэдээлэхгүй.

Хяналтын болон шалгалтын гэрчилгээг ашиглах журмыг Хяналтын Юан тогтооно.

27 дугаар зүйл. Шаардлагатай бол шалгагч нь холбогдох нотлох баримтыг түр хугацаагаар хураан авах, эсхүл бүхэлд нь буюу зарим хэсгийг нь хураан авч болно.

Ингэхдээ эхлээд тухайн байгууллагын даргаас зөвшөөрөл авна. Энэ нь үндэсний эрх ашгийг хохироохгүй бол байгууллагын дарга зөвшөөрөл олгоно.

Байгууллагын дарга нь шалгагчийн хураан авсан нотлох баримт дээр тамгаа дарж, баримт авна.

28 дугаар зүйл. Шалгагч нь орон нутгийн засаг захиргаа, орон нутгийн шүүх болон бусад холбогдох байгууллагаас туслалцаа авч болно.

Шалгагч эсэргүүцэлтэй тулгарсан, эсхүл нотлох баримтыг хамгаалах шаардлагатай гэж үзвэл шаардлагатай арга хэмжээ авахуулахаар цагдаагийн байгууллагад мэдэгдэж болно.

29 дүгээр зүйл. Хэргийг чухал гэж үзсэн, эсхүл шалгуулагч оргон зайлж болзошгүй гэж үзвэл шалгагч урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах талаар орон нутгийн цагдаагийн байгууллагад мэдэгдэж болно.

30 дугаар зүйл. Хяналтын Юан нь тодорхой асуудал, хэргийг мөрдөн шалгахын тулд өөр агентлагт даатгаж болно. Тус байгууллага хэргийг хүлээн авсны дараа нэн даруй мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлж, Хяналтын Юанд бичгээр хариу өгнө.


VI БҮЛЭГ. НЭМЭЛТ ЗААЛТУУД

31 дүгээр зүйл. Энэ хуулийг хэрэгжүүлэх журмыг Хяналтын Юан тогтооно.


32 дугаар зүйл. Энэ хуулийг нийтлэгдсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Энэ хуулийн 1, 2, 5, 6 дугаар зүйл, 22 дугаар зүйлийн нэг дэх хэсгийг 1993 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Хавсралт 4. Хяналтын Юаны бүтэц, зохион байгуулалтын схем



Хавсралт 5. Хяналтын Юаны хяналтын үйл ажиллагааны зураглал



АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- Constitution of the Republic of China (Taiwan). Announced Date: 1947-01-01. <https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=A0000001>
- Government Portal of the Republic of China (Taiwan) - <https://www.taiwan.gov.tw>
- The Control Yuan цахим хуудас <https://www.cy.gov.tw/en/cp.aspx?n=233>
- Organic Law of the Control Yuan. Promulgated on March 31, 1947. <https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=A0010071>
- Control Act. Announced Date: 1947-01-01. <https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=A0030199>

UIH.MN
СУДАЛГААНЫ САН